



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 692

Улаанбаатар хот

Ердийн даатгалын актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 08 дугаар хавсралт “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.4.2, 2.12.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нарангэрэлийн Цэрэнлонжидод ердийн даатгалын актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгосугай.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг Н.Цэрэнлонжидод үүрэг болгосугай.
3. Тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 116 дугаар тогтоол хүчингүй болсонд тооцсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518001491